



# ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛИЙН ТОВЧ ТАЙЛАН

2019-2020 оны хичээлийн жил

# АГУУЛГА

СУРГУУЛЬ, ГЭР  
БҮЛИЙН ОРЧНЫ  
НӨХЦӨЛ  
БАЙДЛЫН БОЛОН  
ЭРСДЛИЙН  
ҮНЭЛГЭЭ

СУРАЛЦАГЧИД БОЛОН  
ЭЦЭГ ЭХЭД ӨГӨХ  
СЭТГЭЛ ЗҮЙ,  
ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ХҮҮХДИЙН ЭРХ,  
ХАМГААЛАЛ,  
БОЛОВСРОЛЫН ТУХАЙ  
ХУУЛИЙГ  
СУРТАЛЧЛАН  
ТАНИУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭ

# СУРГУУЛЬ, ГЭР БҮЛИЙН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫН БОЛОН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

- ❖ Сургуулийн орчинд хүүхэдтэй зүй бус харьцсан болон хүчирхийлэлд өртсөн сурагчдын гэр бүлд **нөхцөл байдлын үнэлгээг** ерөнхий боловсролын 19 сургуульд хийж, эрсдлийн түвшин өндөр гарсан судалгааг хамтарсан багийн гишүүдэд уламжилж хамтран ажиллав.
- ❖ Мөн БСУГ-аас аймгийн ЕБС-иудад хөндлөнгийн үнэлгээгээр **сургалтын орчны эрсдэлийн үнэлгээ** хийж гарсан зөрчлийг арилгуулан ажилласан бөгөөд сурагчдын дунд эрсдэлийн бүлгийг тодорхойлох судалгаа хийхэд 1106 хүүхэд бага эрсдэлтэй, 202 хүүхэд дунд зэргийн эрсдэлтэй үнэлэгдэж, АУБ нар, эцэг эхэд зөвлөгөө өгч ажиллаа.

❖ Хүүхэдтэй зүй бус харьцах явдлын хохирогч, гэмт хэргийн золиос болсон сурагч, түүний гэр бүлийн гишүүдийг холбогдох **ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛЭЭР** ханган ажиллаж байгаа бөгөөд Аймгийн цагдаагийн газартай хамтран **“UNFRIEND”** хөдөлгөөний үйл ажиллагаагаар 3185 эцэг эхэд сургалт, сурталчилгаа зохион байгуулж явууллаа.

❖ ЕБС, цэцэрлэгийн гадна, дотно талыг 80 хувь **камержуулснаар** сурагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжоор хангав.

## ЕБС-ийн суралцагчдын эрсдлийн үнэлгээг тогтоосон байдлыг судалгаагаар харуулбал:

<b>Нийгмийн орчинд гарах эрсдэл</b>	<b>Автобусаар явдаг</b>	<b>660</b>	
	Зам хөндлөн гарч сургуульдаа ирдэг	3810	
	Харанхуй гудамж, жалгаар явж харьдаг	583	
	Хичээлээс гадуур хөдөлмөр эрхэлдэг	19	
	Хөгжлийн бэрхшээлтэй	98	
	РС тоглодог	141	
	Цахим сөрөг мэдээлэл авч ашигладаг	1120	
	Томчуудын дарамтанд өртдөг	20	
<b>Сургуулийн орчинд гарах эрсдэл</b>	Хоцрогдол, таслалттай	130	
	Гадуурхагддаг	11	
	Багшийн ёс зүй /бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтад оруулах, бусад.../	0	
	Үе тэнгийнхний дарамтанд өртдөг	25	
	Оролцоо хангагддаггүй	80	
<b>Гэр бүлийн орчинд гарах эрсдэл</b>	Түрээсийн байр, орч, подвальд амьдардаг	227	
	Гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг	32	
	Эцэг эх ажилгүй, орлого багатай	556	
	/Гэр бүлийн байдал тогтворгүй /салалт, хойд эцэг, эх/	375	
	Тавиул	Гэр нь хөдөө	317
		Эцэг эх нь гадаадад	71
	Ар гэрийн хяналт сул	257	
Архи пиво уудаг хүн бий	185		
<b>Хувийн зан чанараас шалтгаалах эрсдэл</b>	Дээрэнгүй зантай	55	
	Ганцаардмал зожиг	36	
	Бүдүүлэг үг, хэллэг хэрэглэдэг	91	
	Бусдыг уруу татдаг.	43	
	Архи, пиво уудаг	11	
	Тамхи татдаг	63	
	Хулгай хийдэг	3	
	Биеэ авч явах байдал	3	
Бага эрсдэлтэй /1-5/	118		

# СУРАЛЦАГЧИД БОЛОН ЭЦЭГ ЭХЭД ӨГӨХ СЭТГЭЛ ЗҮЙ, ЗАСЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- ❖ Хүүхэдтэй зүй бус харьцдаг болон хүчирхийлэлд өртсөн суралцагчид, түүний гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлээ даван туулахад нь туслах зорилгоор **сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг** давхардсан тоогоор 46 удаа үзүүлж, 12 жилийн 1, 6-р сургуульд **“Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”**-ийг байгуулан ажиллаа.
- ❖ Согтууруулах ундаа, мансууруулах бодисоос хамааралтай эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах тусгай хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, 2019-2020 оны хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгав.

# ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ, БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ

- ❖ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Боловсролын тухай хуулийн холбогдох заалтыг эцэг, эх, асран хамгаалагчдад сурталчлан таниулж хэрэгжүүлэх ажлыг сургууль, цэцэрлэг бүр зохион байгуулж, давхардсан тоогоор 11870 эцэг эхчүүд хамрагдлаа.
- ❖ Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл өгөх чиглэлээр Аймгийн БСУГ-аас “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт зөвлөгөөнийг эцэг эхчүүдийн дунд зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд ЕБС-ын эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл 600 гаруй эцэг эхчүүд хамрагдаж, эдгээр арга хэмжээ, үйл ажиллагаа нь сургалтын байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, багш, сурагчид, эцэг эхчүүдийн хамтын үйл ажиллагааг өрнүүлэх, нийгмийн харилцаанд эерэг хандлагыг хэвшүүлэх, сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэлээ.

- ❖ Анги удирдсан багшид хүүхдийн мэдээллийн нууцыг хадгалах, сэтгэл санааны цочрол, хямралд орсон хүүхэдтэй ажиллах зөвлөгөө өгч хамтран ажиллах чиглэлээр **БСШУС-ын сайдын А/608** тоот тушаалын дагуу андройд утас болон сошиал орчныг албан газар болон сургуулийн орчинд ашиглахгүй байх талаар төрийн болон хувийн хэвшлийн 28 сургуулийн эцэг эх, багш, сурагчдын **гурвалсан гэрээ** байгуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллаж байна.
- ❖ Мөн долоо хоног бүрийн баасан гарагийн сүүлийн хичээлийн **5 минутыг** осол, аюулгүй сурч, хүмүүжих мэдээллийн цаг гарган ажиллаж байна.



- ❖ Хүүхэдтэй зүй бус харьцах, ялгаварлан гадуурхагдах, үе тэнгийнхний дайралт, доромжлолоос хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургуулийн орчинд хэрэгжүүлж, энэ чиглэлээр гарсан аливаа санал санаачлагыг **хүүхдийн сайн дурын байгууллагаар** дамжуулан хамтран ажиллаж байна.
- ❖ ЕБС-ийн сурагчдын хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлсэн боловсролын нийгмийн ажлын үйлчилгээний тухай **бүртгэл мэдээллийн нэгдсэн санг** бий болгох зорилт тавин ажиллаж байна.
- ❖ Мөн Аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн 2018 оны төлөвлөгөөнд **“Интернет орчноос хүүхдээ хамгаалая”** хөтөлбөрийг тусгаж гүйцэтгэл 80 хувь, Аймгийн эцэг эхийн зөвлөлтэй хамран ажиллах БСУГ-ын **“Дархан-444”** хөтөлбөр 60 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.

- Дархан сумын ГХУСАЗСЗ-тай хамтарч хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүүхдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийлэл, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ, кейс дээр ажиллах аргачлал, арга зүйг эзэмшүүлэх зорилгоор хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах **“Хариуцлагатай хамтарсан баг”** дадлага сургалтыг 14 багийн нийгмийн ажилтан, 12 СНА-уудад зохион байгууллаа.

## ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ:

- ❖ Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах.
- ❖ **Цахим гэмт хэргээс** урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхтэй хамтран ажиллах.
- ❖ Хүүхэд хамгааллын чиглэлээр **төсөв хөрөнгө, санхүүжилтын** асуудлыг шийдэх.
- ❖ Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ЕБС-ыг **мэргэжлийн сэтгэл зүйчээр хангах.**
- ❖ Сургууль, цэцэрлэгүүдийн гадна явган хүний гарц, тэмдэг тэмдэглэгээг шинэчилэн байршуулах, **“Гэр- сургууль-гэр”** зураглалын хэрэгжилтийг сайжруулах.



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ,  
УРЛАГИЙН ГАЗАР -2019